

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 3 сарын 20-ны өдөр

№ 20/12

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
хэлэлцэх асуудлын саналд нэмэлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 66.5 болон 66.8 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.3, 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.14 дэх заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2020 оны 2 сарын 03-ны өдрийн 20/09 тоот тогтоол, 2020 оны 3 сарын 20-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 75 (далан тав) хувийг эзэмшигч Анд Системс ХХК-аас 2020 оны 3 сарын 02-ний өдрийн 20/01 тоот албан бичгээр Компанийн ТУЗ-д ирүүлсэн саналыг хүлээн авч, энэхүү тогтоолын Хавсралт No1-р баталгаажуулж, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын дарааллын “Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэн батлах эсэх асуудал” хэсэгт нэмж оруулан, хэлэлцүүлэн шийдвэрлүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолын 2-т заасантай холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2020 оны 2 сарын 03-ны өдрийн 20/08 болон 20/09 тоот тогтоолын холбогдох хэсгүүд, хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичигт нэмэлт оруулсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Комиссын дарга М.Түвшинжаргал), Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 3 сарын 20-ны өдрийн 20/14 тоот тогтоолын

ХАВСРАЛТ №1



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛ

Д/д	Дүрмийн одоогийн зохицуулалт	Дүрэмд шинээр орох өөрчлөлтүүд	Тайлбар
1	4.2 Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд:	4.2.8. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	Компани нь эдгээр үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан тул Компанийн дүрэмд нэмэлт оруулахаар тусгав.
2	4.2 Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд:	4.2.9. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	